БАТЛАВ. БЗӨБЦТС ТӨХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ТАВИНБЭХ

БАГАНУУР ЗҮҮН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК
2008904

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2018 оны 03-р сарын 15-ны өдөр № 15/18 Багануур дүүрэг

1. Техникийн нөхцөл хүссэн иргэн, хуулийн этгээд:	Эрчим хүчний яам
2. Хэрэглэгчийн хаяг:	Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум
3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:	Түмэнцогт сумын гэр хороолол, 3-р зэрэглэл
4. Ажил үйлчилгээний зориулалт:	Сумын гэр хорооллын цахилгаан хангамж, ахуйн хэрэглээ
5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:	Эрчим хүчний сайдын 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/554 тоот албан бичиг
6. Суурилагдсан чадал:	100 кВА
7. Гүйцэтгэх ажил:	**7.1** 10/0.4 кВ-ын АТП-67 дэд өртөөний 0.4 кВ-ын Үет гаргалгаанаас тэжээлтэй модон тулгууртай, АС-50 маркийн дамжуулагчтай ЦДАШ-ыг СИП маркийн 3*50+1*54.6 мм^2 хөндлөн огтлолын талбай бүхий бүрээстэй дамжуулагч, төмөр бетон тулгуураар сольж шинэчлэн угсарна. **7.2** Шинээр татсан 0.4 кВ-ын салбар шугамаас хэрэглэгчдийн байршлыг харгалзан үзэж, 6-н хэрэглэгчийн тоолуур багтах чийг, тоос, шороо орохооргүй битүүмжлэл сайтай, Монгол улсын MNS-5834:2008 стандартын шаардлага хангасан тоолуурын хайрцаг шинээр суурилуулна.
8. Тоолуур хэмжих хэрэгсэл:	**8.1** Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрсөн 1 фазын 40 А-н тарифт электрон тоолуурыг айл өрхөд, 3 фазын 100 А-н

тарифт электрон тоолуурыг төсөвт байгууллагуудад таслах, залгах автоматын хамт шинээр суурилуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр баригдах обьектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.

9.2 Шинээр угсрах ЦДАШ-ын трассын зураг, схемийг Хэнтий ЦТСС-ийн инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-н дагуу тоолуур нэгтгэлийн щит, ЦДАШ-ын 200 метр тутамд давтан газардуулга хийнэ.

9.4 Шинээр баригдах 0.4 кВ-ын ЦДАШ нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эрх бүхий байгууллагаас газрын зөвшөөрөл авч, Хэнтий аймгийн газрын албаны мэдээллийн санд оруулна.

9.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

9.6 0.4 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт, хэмжилтийг Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

9.8 Хуучин ашиглагдаж байсан ЦДАШ-ыг буулгаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх. Хуучин тулгуурын нүхийг шороогоор булна.

9.9 СИП кабель угсралтын ажлыг хийхдээ технологийн картыг БЗӨБЦТС ТӨХК-иар батлуулж, түүний дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.

9.10 Шинээр суурилуулах СИП кабель, бетон тулгуур, тоноглолууд нь үйлдвэрийн сертификат, Эрчим хүчний хөгжлийн төвийн цахилгааны лабораторийн туршилтанд орсон протоколтой байна.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох обьектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу холбогдоно.

10.2 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг **хоёр** жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

Хянасан: ТҮАХТэргүүн дэд захирал,

Ерөнхий инженер – Г Г.Шүрэнчулуун

Засварын ахлах инженер А.Лхамсүрэн

Боловсруулсан: ТНОЗ-ийн инженер Д.Нямдорж